# ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

| Д/Д | Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах; | Төлөвлөгөөний тоо | 1 | 1 | Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталсан. |
| 2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах; | Дүгнэлтийн тоо | Тухай бүр | 1 | 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төвд иргэн С.Нямдаваагаас Нийслэл хариуцсан хэлтсийн үйлчилгээний ажилтантай холбоотой гомдол ирүүлснийг тус газрын Ёс зүйн дэд хороонд шилжүүлсний дагуу хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан. |
| 3 | Байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа хийх; | Судалгааны тоо | 2 | 1 | Нийслэл, орон нутгийн нийт албан хаагчдын дунд байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа авч үр дүнг нэгтгэн удирдлагад танилцуулсан. Тус судалгаанд нийт 115 албан хаагч хамрагдаж байгууллагын дотоод уур амьсгал, үүсэж байгаа болон ирээдүйд үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, эрсдэлийг тодорхойлсон. |
| 4 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх; | Тайлангийн тоо | 2 | 1 | 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны 01 дүгээр улирлын тайланг хүргүүлсэн. |
| 5 | Ёс зүйн зөрчил гаргасан талаар гомдол, мэдээллийг | Хянан шийдвэрлэсэн | Тухай бүр | 2 | Орхон аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйлчилгээний ахлах ажилтантай холбоотой 1, Нийслэл |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хянан шийдвэрлэх хуралдааныг тухай бүрд нь зохион байгуулах. | гомдол мэдээллийн тоо | | | хариуцсан хэлтсийн үйлчилгээний ажилтантай холбоотой 1 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж холбогдох албан хаагчид мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд Орхон аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйлчилгээний ахлах ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж Нийслэл хариуцсан хэлтсийн үйлчилгээний ажилтантай холбоотой гомдлыг ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэж Ёс зүйн дэд хорооны хурлын дүгнэлтийг холбогдох албан тушаалтан, гомдол ирүүлсэн этгээд, гомдолд холбогдогч этгээдэд хүргүүлж ажилласан. |

ХЯНАСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
Б.ОДБАЯР

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН: ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Н.АЛТАНСУВД